БАТЛАВ:
УЛСЫН БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА С.МЭНДСАЙХАН

**УЛСЫН БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН**
**ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН 2016 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| **Үүсч буй эрсдэл** | **Хэрэгжүүлэх арга хэмжээ** | **Хамрагдах нэгжүүд** эсвэл (Хамрах хүрээ) | **Эрсдэлийн код** | **Эрсдэлийн үнэлгээ** | **Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт** | | **Хариуцах эзэн** |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Арга хэмжээний шалгуур үзүүлэлт / тоо, чанар,** хугацаа /-ийн хүрэх түвшин | **Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин** | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **"Нэг. Төсөв санхүүгийн эрсдэлийг удирдах"** | | | | | | | |
| 1. Албан ёсны эрх бүхий вирусын хамгаалалтгүйн улмаас компьюерүүд удах, гацах, мэдээлэл алдагдах, сүлжээ доголдох. | 1.1. Албан ёсны эрх бүхий вирусын эсрэг программын судалгааг хийнэ.<br>1.2. Вирусын эсрэг программыг худалдан авахад шаардлагатай төсвийг байгууллагын 2017 оны төсөвт тусгуулахаар дээд шатны байгууллагад санал хүргүүлнэ. | Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын газар, хэлтэсүүд, 21 аймгийн Улсын бүртгэл, статистикийн газрыг хамарна. | D1 | 20 | 1.1. Албан ёсны эрх бүхий вирусын эсрэг программын судалгааг хийсэн байна.<br>/ 4-р сард /<br>1.2. Вирусын эсрэг программыг худалдан авахад шаардлагатай төсвийг байгууллагын 2017 оны төсөвт тусгуулахаар, дээд | 2017 оны Төсөвт суугдсан байна. | Төрийн захиргаа удирдлагын газрын дарга, Мэдээлэл боловсруулалт,технологийн газрын дарга, |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шатны байгууллагад саналыг хүргүүлнэ. / 8-р сарын 1-ний өдрийн дотор / | | |
| 2. Сар бүрийн төсвийн санхүүжилт хугацаа хоцорч ирсэнээс тухайн сард төлвөл зохих урсгал зардалууд төлөгдөхгүй сар дамжин өр, авлага үүсэх, нэмэгдэх, төлөвлөгдсөн зарим ажил хойшлогдох. | 2.1. Өр, авлагыг барагдуулна.<br>2.2. Холбогдох дээд шатны байгууллагаас дэмжлэг хүснэ. | Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар, аймаг, нийслэлийн бүртгэл, статистикийн газар | D2 | 20 | 2.1. Нийт 1,671,960,646.05 төгрөгийн өр, 89,081,498.24 төгрөгийн авлагыг барагдуулна.<br>2.2. Сар бүрийн төсвийн санхүүжилтийг хугацаанд нь шийдвэрлэх талаар удирдлагын зүгээс дээд шатны байгууллагад тухай бүр санал, хүсэлтээ уламжилна.<br>/ Сар тутам / | Өр, авлагыг барагдуулсан байна. | Төрийн захиргаа удирдлагын газрын дарга, Санхүүгийн хэлтсийн дарга |
| 3. Байгууллагын бүтцийн өөрчлөлтийн улмаас цомхотголд орсон албан хаагчдын тэтгэмжийн мөнгө 2016 оны төсөвт суугаагүй байх. | 3.1. Байгууллагын бүтцийн өөрчлөлтийн улмаас цомхотголд орсон албан хаагчдын тэтгэмжийн мөнгийг байгууллагын холбогдох төсвөөс олгох арга хэмжээ ажиллана. | Цомхотголд орсон албан хаагчид | D3 | 25 | 3.1. Бүтцийн өөрчлөлтийн улмаас цомхотголд орсон албан хаагчдын тэтгэмжийн мөнгийг байгууллагын холбогдох зардлаас олгоно.<br>/ 4-р сард / | Тухайн эрсдэл арилсан байна. | Төрийн захиргаа удирдлагын газрын дарга, Санхүүгийн хэлтсийн дарга |
| 4. Мэдээлэл нөөцлөх зориулалт бүхий стораж дүүрч, бүртгэлийн систем зогсох, доголдох. | 4.1. Иргэний бүртгэлийн болон хүний биеийн давхцахгүй өгөгдлийн /8TB/, хуулийн этгээдийн бүртгэлийн болон архивын /15TB/, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн /20TB/, цахим архивын /15TB/, нийт 65TB орчим хэмжээтэй мэдээллийг нөөцлөх стораж суурилуулахад шаардлагатай | Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын Мэдээлэл боловсруулалт, технологийн газрыг хамарна. | D4 | 9 | 4.1. Нийт 65TB орчим хэмжээтэй мэдээлэл нөөцлөх сторажийг суурилуулахад шаардлагатай төсвийг байгууллагын 2017 оны төсөвт тусгуулахаар, дээд шатны байгууллагад саналыг хүргүүлсэн байна. / 8-р | 2017 оны Төсөвт суугдсан байна. | Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, Мэдээлэл боловсруулалт, технологийн газрын дарга |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төсвийг байгууллагын 2017 оны төсөвт тусгуулна.<br>4.2. Хууль зүйн яамнаас дэмжлэг хүснэ. | | | | сарын 1-ний өдрийн дотор / | | |
| 5. Улсын бүртгэлийн төв архивын газарт цаасан баримт ихээр хадгалагддаг тул галын аюул гарч болзошгүй, 2016 оны төсөвт утаа мэдэрдэг дохиололын систем суурьлуулах төсөв тусгагдаагүйгээс гал гарвал үйл ажиллагаанд доголдол үүсэх. | 5.1. Стандартын шаардлага хангасан утаа мэдэрдэг дохиололын системтэй болох арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.<br>5.2. Дохиололын системийг худалдан авах, суурилуулахад шаардлагатай төсвийг байгууллагын 2017 оны төсөвт тусгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн төв архивын газрыг хамарна. | D5 | 15 | 5.1. Стандартын шаардлага хангасан утаа мэдэрдэг дохиололын системийн судалгаа хийсэн байна. / 5-р сард /<br>5.2. Дохиололын системийг худалдан авч суурилуулахад шаардлагатай төсвийг байгууллагын 2017 оны төсөвт тусгуулахаар дээд шатны байгууллагад саналыг хүргүүлсэн байна. / 8-р сарын 1-ний өдрийн дотор / | 2017 оны Төсөвт суугдсан байна. | Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, Улсын бүртгэлийн төв архивын газрын дарга |
| 6. Тухайн онд хийж, гүйцэтгэх ажил, үйлчилгээтэй холбогдон батлагдсан төсөвт тодотгол хийх замаар төсвийг хасаж, хийхээр төлөвлөсөн ажлууд бүрэн төгс хийгдэхгүй байх. | 6.1. Тодотгол хийх замаар батлагдсан төсвийг хасуулахгүй байх талаар арга хэмжээ авч ажиллана. | Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын газар хэлтэсүүд, 21 аймгийн Улсын бүртгэл статистикийн газрыг хамарна. | D6 | 12 | 6.1. Батлагдсан төсвийг хасахгүй байх талаар дээд шатны байгууллагад санал, хүсэлтээ уламжилна.<br>/ 4-р сард / | Батлагдсан төсвийг тодотголоор хасуулахгүй байснаар төлөвлөгөөт ажлууд бүрэн хийгдэж, биелэгдсэн байна. | Төрийн захиргаа удирдлагын газрын дарга, Санхүүгийн хэлтсийн дарга |
| 7. Үндэсний дата төвд байрлуулсан серверийн хүчин чадал муу, мэдээлэл солилцох систем | 7.1. Уг системийн кластер /cluster/ систем болгох, 1 сервер, 1 стораж нэмж авах талаар тооцоо судалгааг боловсруулна. | Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын Мэдээлэл, боловсруулалт | D7 | 12 | 7.1. 1 сервер, 1 стораж нэмж авахад шаардлагатай төсвийн тооцоо судалгааг хийсэн байна. / 6-р | 2017 оны Төсөвт суугдсан байна. | Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| удаан байгаа нь бусад төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцоход доголдол үүсэх. | 7.2. Байгууллагын 2017 оны төсөвт тусгуулна. | технологийн газрыг хамарна. | | | сард / 7.2. 1 сервер, 1 стораж нэмж авахад шаардлагатай төсвийг байгууллагын 2017 оны төсөвт тусгуулахаар, дээд шатны байгууллагад саналыг хүргүүлсэн байна. / 8-р сарын 1-ний өдрийн дотор / | | Мэдээлэл боловсруулалт, технологийн газрын дарга |
| 8. Тооллого, судалгааны зардал хүрэлцээ муутай байх нь цуглуулж буй анхдагч мэдээллийн чанарт муугаар нөлөөлөх | 8.1. Тооллого, судалгаа хийхэд шаардлагатай зардлын судалгааг боловсруулна.<br>8.2. Шаардлагатай төсвийг байгууллагын 2017 оны төсөвт тусгуулна. | Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын Тооллого, судалгаа, мэдээллийн газрыг хамарна. | D8 | 12 | 8.1. Тооллого, судалгаа хийхэд шаардлагатай зардлын тооцоо судалгааг гаргасан байна.<br>/ 4-р сард /<br>8.2. Шаардлагатай зардлыг байгууллагын 2017 оны төсөвт тусгуулахаар, дээд шатны байгууллагад саналыг хүргүүлнэ.<br>/ 8-р сарын 1-ний дотор / | 2017 оны Төсөвт суугдсан байна. | Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, Тооллого, судалгаа, мэдээллийн газрын дарга |
| 9. Компьютер, техник, тоног төхөөрөмж хуучирч элэгдэх. | 9.1. Компьютер, техник, тоног төхөөрөмжийн тооцоо судалгааг боловсруулна.<br>9.2. Компьютер, техник, тоног төхөөрөмж шинээр худалдан авахад шаардлагатай төсвийг байгууллагын 2017 оны төсөвт тусгуулна. | Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын газар хэлтэсүүд, 21 аймгийн Улсын бүртгэл статистикийн газрыг хамарна. | D9 | 8 | 9.1. Шинээр худалдан авахад шаардлагатай компьютер, техник, тоног төхөөрөмжийн тооцоо судалгааг гаргасан байна.<br>/ 6-р сард /<br>9.2. Шаардлагатай төсвийг байгууллагын 2017 оны төсөвт тусгуулахаар, дээд шатны байгууллагад | 2017 оны Төсөвт суугдсан байна. | Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, Санхүүгийн хэлтсийн дарга |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | саналыг хүргүүлсэн байна. / 8-р сарын 1-ний өдрийн дотор / | | |
| 10. Тооллого судалгааны санхүүжилт төлөвлөсөн хугацаандаа хийгдэхгүйгээс судалгааны дүн, график хугацаа алдагдах. | 10.1. Тооллого, судалгааг төлөвлөсөн хугацаанд хийх зорилгоор холбогдох санхүүжилтийг хугацаанд нь шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана. | Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын Тооллого, судалгаа, мэдээллийн газрыг хамарна. | D10 | 12 | 10.1.1. Төсвийн санхүүжилтийг хугацаанд нь шийдвэрлэх талаар удирдлагын зүгээс дээд шатны байгууллагад санал, хүсэлтээ уламжилна. / 4-р сард / 10.1.2. Тооллого, судалгааны дүнг тогтоосон хугацаанд хэрэглэгчдэд мэдээлж ажиллана. / Сар бүр / | Тухайн эрсдэл арилсан байна. | Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, Тооллого, судалгаа, мэдээллийн газрын дарга |
| **“Хоёр. Үйл ажиллагааны эрсдэлийг удирдах”** | | | | | | | |
| 11. УБЕГ-ын барилга хуучирч муудсаны улмаас ус, дулааны шугам сүлжээ, бохирын шугам, цахилгааны холболт зэргээс шалтгаалан гэнэтийн осол аваар гарах | 11.1. Хан-Уул дүүргийн 10 дугаар хороонд архивын байрны зориулалтаар олгогдсон газарт, баригдах архивын барилгын зураг төслийг батлуулах арга хэмжээ авч ажиллана. 11.2. Батлагдсан зураг төсөл, тооцоо судалгаанд үндэслэн байр бариулах шаардлагатай төсвийг байгууллагын 2017 оны төсөвт тусгуулахаар санал хүргүүлнэ. | Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрыг хамарна. | D11 | 15 | 11.1.1. Архивын барилгын зураг төслийг хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулна. / 5-р сард / 11.1.2. Архивын барилгын зураг төслийг холбогдох газраар батлуулна. / 7-р сард / 11.2. Батлагдсан зураг төсөл, тооцоо судалгаанд үндэслэн байр бариулах шаардлагатай төсвийг байгууллагын 2017 оны төсөвт тусгуулахаар, | 2017 оны Төсөвт суугдсан байна. | Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, Улсын бүртгэлийн төв архивын газрын дарга |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дээд шатны байгууллагад саналыг хүргүүлсэн байна. / 8-р сарын 1-ний өдрийн дотор / | | |
| 12. УБЕГ-ын төв байрны цахилгааны ерөнхий оруулгын кабелийн утас тасрах. | 12.1. Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын барилгуудад шаардлагатай урсгал засварын ажлыг хийх, тооцоо судалгааг боловсруулна.<br>12.2. Шаардлагатай төсвийг байгууллагын 2017 оны төсөвт тусгуулна. | Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрыг хамарна. | D12 | 15 | 12.1. Урсгал засварын ажлыг хийх, тооцоо судалгааг гаргасан байна. / 5-р сард /<br>12.2. Урсгал засварын ажлыг хийхэд шаардлагатай төсвийг байгууллагын 2017 оны төсөвт тусгуулахаар, дээд шатны байгууллагад саналыг хүргүүлсэн байна. / 8-р сарын 1-ний өдрийн дотор / | 2017 оны Төсөвт суугдсан байна. | Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, Санхүүгийн хэлтсийн дарга |
| 13. Байгууллагын бүтэц тогтворгүй, богино хугацаанд бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөж байгаагаас бүртгэл, статистикийн хараат бус байх зарчим алдагдах, нөгөө талаас нийт албан хаагчдын ажилдаа хандах хандлага, идэвхи, чармайлт суларч, үйл ажиллагаа доголдоход хүрч болзошгүй. | 13.1. Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг ойр ойрхон хугацаанд хийхгүй байх талаар холбогдох дээд шатны байгууллагад удирдлагын зүгээс санал тавьж ажиллана.<br>13.2. Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн улмаас байгууллагын үйл ажиллагаа доголдох эрсдэл гаргахгүйн тулд албан хаагчдын ажилдаа хандах хандлага, идэвхи чармайлалтыг бууруулахгүй байхаар зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллана. | Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрыг хамарна. | D13 | 25 | 13.1. Удирдлагын зүгээс бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг ойр ойрхон хийхгүй байх талаар холбогдох дээд шатны байгууллагад санал хүсэлтээ уламжилна.<br>/ 5-р сард /<br>13.2. Албан хаагчдыг чадваржуулах, хөгжүүлэх сургалтуудыг практикт тулгуурласан шинэлэг хэлбэрээр зохион байгуулж, түүнд зөвхөн дарга, удирдлага бус албан | Тухайн эрсдэл арилсан байна. | Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, Хүний нөөцийн хэлтсийн дарга |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хаагчдыг өргөнөөр хамруулна.<br>/ 9-р сард / | | |
| 14. Иргэний шинэчилсэн бүртгэлийн серверийн ашиглалтын хугацаа дууссан нь бүртгэлийн хэвийн үйл ажиллагааг доголдоход хүргэх. | 14.1. Иргэний шинэчилсэн бүртгэлийн серверийг шинэчлэх арга хэмжээ авч ажиллана.<br>14.2. Шаардлагатай төсвийг байгууллагын 2017 оны төсөвт тусгуулна. | Улсын бүртгэл статистикийн ерөнхий газрын газар, хэлтэсүүдийг хамарна. | D14 | 12 | 14.1. Шаардлагатай тооцоо судалгааг хийсэн байна.<br>/ 5-р сард /<br>14.2. Шаардлагатай төсвийг байгууллагын 2017 оны төсөвт тусгуулахаар, дээд шатны байгууллагад саналыг хүргүүлсэн байна. / 8-р сарын 1-ний өдрийн дотор / | 2017 оны Төсөвт суугдсан байна | Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, Мэдээлэл боловсруулалт, технологийн газрын дарга, Иргэний бүртгэл, гадаад паспортын газрын дарга |
| 15. Цалингийн сүлжээ, систем үр нөлөө муутай ажилтнуудын ажлын ачаалалтай уялдаагүй, уян хатан биш. | 15.1. Цалингийн нэмэгдлүүдийг зохих журмын дагуу шинэчилж олгох арга хэмжээ авна. | Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрыг хамарна | D15 | 12 | 15.1.1. Албан хаагчдын цалингийн шатлал, зэрэг дэв, ур чадвар, ажилласан жилийн нэмэгдэл зэрэг хууль, журмаар зохицуулагдсан нэмэгдлүүд албан хаагч нэг бүрийн хувьд үндэслэлтэй, бодит тогтоогдсон эсэхэд судалгаа хийнэ. / 5-р сард /<br>15.1.2. Шаардлагатай нэмэгдлүүдийг албан хаагчдад зохих журмын дагуу шинэчлэн олгоно. | Тухайн эрсдэл арилсан байна. | Төрийн захиргаа удирдлагын газрын дарга, Санхүүгийн хэлтсийн дарга |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | / 6-р сард / | | |
| 16. Цахим мэдээллийн санг бүрэн ашиглах боломжгүй нөхцөлд хүрэх. | 16.1. Цахим мэдээллийн санг бүрэн ашиглахад шаардлагатай төсөл, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ. | Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын Мэдээлэл, боловсруулалт технологийн газар, Улсын бүртгэлийн төв архивын газрыг хамарна. | D16 | 15 | 16.1.1. Цахим мэдээллийн санг бүрэн ашиглахад шаардлагатай төсөл, хөтөлбөрийг боловсруулж, дээд шатны байгууллагад саналыг хүргүүлнэ / 7-р сард / 16.1.2. Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлно. / 8-р сард / 16.1.3. Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх аж ахуйн нэгж байгууллагын сонгон шалгаруулалтыг зохион байгуулна. / 9-р сард / | Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. | Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, Мэдээлэл боловсруулалт, технологийн газрын дарга, Улсын бүртгэлийн төв архивын газрын дарга |
| **"Гурав. Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэлийг удирдах"** | | | | | | | |
| 17. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн зарим заалт Улсын бүртгэлийн ерөнхий хуультай зөрчилдсөнөөс үйл ажиллагаандаа дагаж | 17.1. Хуулийн төслийг батлуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллана. | Улсын бүртгэл статистикийн ерөнхий газрыг хамарна. | D17 | 15 | 17.1.1. Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт холбогдох албан хаагчид оролцоно. 17.1.2. Хууль батлуулах чиглэлээр холбогдох арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлэх талаар дээд шатны байгууллагад байнга санал, хүсэлтээ уламжилна. | Хууль батлагдаж тухайн эрсдэл арилсан байна. | Төрийн захиргаа удирдлагын газрын дарга, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| мөрдөхгүй байх. | | | | | | | |
| 18. Иргэний бүртгэлийн тухай хуулийн зарим заалт Улсын бүртгэлийн ерөнхий хуультай зөрчилдсөнөөс үйл ажиллагаандаа дагаж мөрдөхгүй байх. | 18.1 Хуулийн төслийг батлуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллана. | Улсын бүртгэл статистикийн ерөнхий газрыг хамарна. | D18 | 15 | 18.1.1 Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт холбогдох албан хаагчид оролцоно.<br>18.1.2. Хууль батлуулах чиглэлээр холбогдох арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлэх талаар дээд шатны байгууллагад байнга санал, хүсэлтээ уламжилна. | Хууль батлагдаж тухайн эрсдэл арилсан байна. | Төрийн захиргаа удирдлагын газрын дарга, Иргэний бүртгэл, гадаад паспортын газрын дарга |
| **“Дөрөв. Давагдашгүй буюу гадаад хүчин зүйлсийн эрсдэлийг удирдах”** | | | | | | | |
| 19. 100-н айл дахь үйлчилгээний байрууд, Сонгинохайрхан дүүргийн бүртгэл, статистикийн хэлтэс, Баянзүрх дүүргийн бүртгэл, статистикийн хэлтсийн байрууд гэр хороолол дунд байрладаг тул өвөл утаа ихтэй байдаг нь албан хаагчдын эрүүл мэндэд муугаар нөлөөлөх. | 19.1 Утаа шүүж, агаар цэвэршүүлэх тоног төхөөрөмжийг авч ажиллуулах талаар холбогдох арга хэмжээ авна.<br>19.2 Шаардлагатай төсвийг байгууллагын 2017 оны төсөвт тусгуулна. | Улсын бүртгэл статистикийн ерөнхий газар, дүүргийн Улсын бүртгэл, статистикийн хэлтэс хамарна. | D19 | 20 | 19.1. Утаа шүүж, агаар цэвэршүүлэх тоног төхөөрөмжийн үнийн судалгааг боловсруулсан байна. / 5-р сард /<br>19.2. Шаардлагатай төсвийг байгууллагын 2017 оны төсвийн төсөлд тусгуулахаар, дээд шатны байгууллагад саналыг хүргүүлсэн байна.<br>/ 8-р сарын 1-ний өдрийн дотор / | 2017 оны төсөвт суугдсан байна. | Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, Санхүүгийн хэлтсийн дарга |
| 20. Улсын бүртгэлийн мэдээллийн сан буюу төв сервер тус газрын төв байранд байрладагтай холбоотойгоор цахилгаан тасарсан | 20.1 Тог баригч /генератор/ авч ажиллуулах талаар холбогдох арга хэмжээ авна.<br>20.2 Шаардлагатай төсвийг байгууллагын 2017 оны төсөвт тусгуулна. | Улсын бүртгэл статистикийн ерөнхий газрыг хамарна. | D20 | 15 | 20.1. Тог баригч /генератор/-ын үнийн судалгааг гаргана.<br>/ 5-р сард /<br>20.2 Тог баригч /генератор/-ыг худалдан авахад шаардлагатай | 2017 оны төсөвт суугдсан байна. | Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, Мэдээлэл боловсруула |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| хэмжээнд сүлжээ тасрах, үйл ажиллагаа доголдох. | | | | | 2017 оны төсөвт тусгуулахаар, дээд шатны байгууллагад саналыг хүргүүлнэ. / 8-р сарын 1-ний өдрийн дотор / | | технологийн газрын дарга |

- - - oOo - - -